



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 274

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.4 дахь заалт, "Мэдээ тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалт, 2023 оны "Тогтоолын нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 467 тогтоолын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Өвөрхангай аймгийн Онцгой байдлын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 2 нэрийн, нийт 11,900,000.00 (арван нэгэн сая есөн зуун мянга) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий автомашины хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаанд оролцогч ирээгүй тул нээлттэй дуудлагын худалдааг дахин (3 дахь) зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2. Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Г.Ариунбуян, Өвөрхангай аймгийн Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа Д.Одонбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Орон нутгийн өмчийн газраас төлөөлөгчийг оролцуулан үндсэн хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар, худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг (холбогдох зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Автомашиныг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2024 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132001540

15-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн
274 дугаар тогтоолын хавсралт



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ,НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР
ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон он	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	ТӨБЗГ-ын 2022 оны 72 дугаар тогтоолоор тогтоосон доод үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон худалдах доод үнэ (төгрөг)
1	Портер, улсын дугаар 41-76 ӨВР	1995/2012	5,900,000.00	1,000,000.00	600,000.00
2	Бонго, улсын дугаар 26-30 ӨВР	1995/2010	6,000,000.00	1,000,000.00	600,000.00
Нийт дүн			11,900,000.00	2,000,000.00	1,200,000.00
			(арван нэгэн сая есөн зуун мянга)	(хоёр сая)	(нэг сая хоёр зуун мянга)